

“СҮРЬЕЭ БОЛОН ЯМ ӨВЧНИЙ ХЯНАЛТ” ТӨСЛИЙН ХАМТАРСАН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДӨРӨВДҮГЭЭР ХУРЛЫН ШИЙДВЭР

Огноо: 2025 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн 8:50-13:00 цагт (Улаанбаатарын цаг)

Хаана: Монгол Улс, ЭМЯ-ны хурлын Б заал

Оролцогчид: Хамтарсан зохицуулах хорооны дарга, гишүүд

Японы Олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллага, Эрүүл мэндийн судалгаа, хөгжлийн байгууллагын "Тогтвортой хөгжлийн төлөө шинжлэх ухаан, технологийн судалгааны түншлэл" (SATREPS)-ийн дэмжлэгтэй “Сүрьеэ болон ям өвчний хяналт” төслийн Хамтарсан зохицуулах хороо (ХЗХ)-ны дөрөвдүгээр хурлыг 2025 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн 08.50-13.00 (Улаанбаатарын цаг) цагийн хооронд танхим болон онлайн хэлбэрээр зохион байгууллаа. Хурлыг батлагдсан хөтөлбөрийн дагуу ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга, төслийн захирал Л.Баттөр удирдсан бөгөөд хуралд оролцох 96 гишүүнээс оролцсон 71 буюу хурлын ирц 74 хувьтай байв. Онлайн 15 оролцогч, 56 танхимаар албан тушаалтан оролцов.

Тус зохицуулах хорооны хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа, анхаарах асуудал
2. “Сүрьеэ, ям өвчний хяналт” хамтарсан төслийн хүрээнд зоонозын халдварт өвчний нэгдсэн платформыг бий болгож хөгжүүлэх

Шийдвэрлэсэн:

1. Төслийн хүрээнд нэгэнт бий болсон зоонозын халдварт өвчнийг оношлох, тандан судлах шинэ техник, технологид суурилсан аргуудыг Монгол Улсын хүн, мал эмнэлгийн байгууллагуудын үйл ажиллагаанд дагаг мөрддөг стандарт, заавар удирдамжид оруулан бүртгэх, баталгаажуулж, хэрэглэх, цаашид тогтвортой байдлыг хангах төлөвлөгөө гаргаж ажиллахыг МЭЕГ, МЭЭШХ, ХӨСҮТ-д тус тус даалгах;
2. Төслийн хүрээд шинээр байгуулагдсан “Био-аюулгүй байдлын 3-р зэрэглэлийн иж бүрэн лаборатори”, Бичил биетний геномийн генийн бүрэн дарааллыг тогтоох “Next generation sequence”-ийн лаборатори болон орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан тоног төхөөрөмж зэргийн үзлэг-засвар үйлчилгээний болон урсгал зардал, шинээр бий болгосон оношлуурыг үйлдвэрлэхэд шаардлагатай урвалж, бодисоор тасралтгүй

- хангах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг ЭМЯ болон МЭЕГ (МЭЭШХ, ХӨСҮТ)-д тус тус үүрэг болгох;
3. Монгол Улс үхрийн сүрьеэ (M.Bovis)-ийн халдвараас ангижирсан талаар Засгийн газар, Олон улсад мэдээлэх бэлтгэх хангах ажлын хэсгийг ЭМЯ, МЭЕГ, МЭЭШХ, ДЭМБ, ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн төлөөлүүдийг оруулан 2025 оны 3 дугаар сард багтаан байгуулж, хамтарсан эрсдлийн үнэлгээ хийж, үр дүнг мал эмнэлэг болон ЭМЯ-ны холбогдох мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэх;
 4. Монгол Улсад үндэсний хэмжээнд Нэг эрүүл мэнд (One health) үзэл баримтлалд тулгуурласан зоонозын халдварт өвчнийг тухайлбал “Ям, болон Сүрьеэ өвчнийг хянах, тэмцэх” платформыг ХӨСҮТ-ийн цахим хуудаст нээн ажилуулах, МЭЭШХ (МЭЕГ-ийн удирдлагын доор) нь уг платформыг хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангахад хамтран ажиллахыг ХӨСҮТ, МЭЭШХ тус тус даалгах;
 5. Тус төслийн хүрээнд хүн, мал эмнэлгийн салбарын бэлтгэгдсэн мэргэжилтэн, боловсон хүчний мэдлэг, ур чадварыг байнга дээшлүүлж, чадавхжуулж, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр зохих арга хэмжээ авахыг МЭЭШХ, ХӨСҮТ-д тус тус даалгахыг оролцогч талууд санал нэгдэв.

БАТАЛГААЖУУЛСАН:

ЭМЯ-НЫ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА,
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ



Л.БАТТӨР